


МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 383

Улаанбаатар хот

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн
үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Хорооны 2014 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20 дахь зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 383,047,882 /гурван зуун наян гурван сая дөчин долоон мянга найман зуун наян хоёр/ ширхэг энгийн хувьцааг 30,824,199 /гучин сая найман зуун хорин дөрвөн мянга нэг зуун ерэн ес/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 413,872,081 /дөрвөн зуун арван гурван сая найман зуун далан хоёр мянга наян нэг/ ширхэг хувьцаатай байхаар үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /М.Болор/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Ж. Алдаржавхлан /-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь мэдээлж, хууль тогтоомж болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК /Ц.Наранчанга/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З. НАРАНТУЯА

001030